



УХААЛАГ ПҮҮНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, НЭВТРЭХ СИСТЕМ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер Ухаалаг пүүний тоног төхөөрөмж, нэвтрэх систем
шалгаруулалтын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
нэр:

Тендер ЭТТХК/20240102487
шалгаруулалтын дугаар:

2024 он

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|--|--|
| 1. Тендерийн цар хүрээ | 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана. |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг | 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж | 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. |
| 4. Худалдан авах ажиллагааны цахим систем | 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна. |
| 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх | 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |

- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч** **этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

Б.АГУУЛГА

- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**
- 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
- I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
 - II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
 - III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
 - IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
 - V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
 - VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
- 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.
- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- B. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
 - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
 - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
 - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
 - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
 - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
 - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
 - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
 - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
 - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

- | | | |
|---|---------------|--|
| 14. Тендерийн маягтууд | жишиг | 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ. |
| 15. Хувилбарт санал | | 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ. |
| 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг | | 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална. |
| 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг баримт бичиг | нотлох | 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй. |

- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээллэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсэн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарыт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 24. Тендерийн баталгаа**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маят 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
- Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**
- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Давуу эрх олгох		31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт		31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендэрээс татгалзах үндэслэл болохгүй.
33. Тендерийн харьцуулах тодорхойлох	үнийг	31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
34. Тендерийг эрэмбэлэх		32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
35. Оролцогчийн чадавхыг магадлах	дахин	33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална. 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална. 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ		
36. Шийдвэр хүргүүлэх		36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: “Эрдэнэс Тавантолгой” ХК
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Ухаалаг пүүний тоног төхөөрөмж, нэвтрэх систем
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: ЭТТХК/20240102487
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Багцгүй”
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: “Байхгүй”
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгөөр
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 2,063,453,000 төгрөг (Хоёр тэрбум, жаран гурван сая, дөрвөн зуун тавин гурван мянга)
Б. АГУУЛГА	
ТШЗ 8.1	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: “Эрдэнэс Тавантолгой” ХК</p> <p>Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиоджавын-8, Финанс төв, 5-р давхар, 504 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс</p> <p>Утасны дугаар: 75055555 дотуур утас-504</p> <p>Сонирхогч этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчаас авах хүсэлтийг бичгээр эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргаж болно.</p> <p>Тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээлэлтэй холбогдуулан захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах эрхтэй ба энэ нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг байна.</p> <p>Захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр хүсэлтийг тодруулгын хамт албан бичгээр гаргаж Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлнэ. Ийнхүү нийтэлсэн даруйд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх сонирхогч этгээдүүдэд нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно.</p> <p>Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэх үүрэгтэй.</p>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендерийн шалгаруулалтын хэл: “Монгол хэл” байх ба өөр хэл дээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулгын хамт бэлтгэн ирүүлнэ.

ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “ Зөвшөөрөхгүй ”
ТШЗ 16	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр дамжуулан шалгана. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ. <p>Анхааруулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэг сонгож цахим хэлбэрээр ирүүлнэ. Түншлэлээр оролцож буй тохиолдолд түншлэлийн төлөөлөх эрх бүхий этгээд нь түншлэлийн гэрээг цахим системд баталгаажуулсны дараа гишүүн этгээдийн хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэгт сонгож илгээнэ.</p> <ol style="list-style-type: none"> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-т заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр гарган баталгаажуулж ирүүлнэ.
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “ Үгүй ”
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “ Шаардахгүй ”
ТШЗ 18.1	<ol style="list-style-type: none"> Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардахгүй” Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардана” <p>Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд төсөөт өртгийн 20 хувь буюу 412,690,600 /дөрөвнөн зуун арван хоёр сая зургаан зуун ерэн мянга зургаан зуу/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хийж гүйцэтгэсэн гэрээний хуулбар /Гэрээний үнийн дүнгээр тооцуулах ижил төстэй ажлын туршлагыг хангах ажил гүйцэтгэх гэрээг иж бүрнээр, хавсралт, нэмэлт хийгдсэн бол гэрээний нэмэлтийн хамт хавсралтаар ирүүлнэ./ - Гэрээ дүгнэсэн акт <p>Ижил төстэй гэдэгт: Радио давтамж /RFID/ ашиглан мэдээлэл дамжуулах систем нийлүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн туршлагыг тооцно.</p>

	<p>3. Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардахгүй”</p> <p>4. Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> - Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь төсөвт өртгийн 20 хувь буюу 412,690,600 /дөрвөн зуун арван хоёр сая зургаан зуун ерэн мянга зургаан зуу/ төгрөгөөс багагүй байна. - Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Төсөвт өртгийн 20 хувь буюу 412,690,600 /дөрвөн зуун арван хоёр сая зургаан зуун ерэн мянга зургаан зуу/ төгрөгөөс багагүй байна. - Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй байна.
ТШЗ 18.2	Тусгай зөвшөөрөл: “Шаардахгүй”
ТШЗ 19.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”</p> <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн тайланг өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй ба тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг Сангиин яамны санхүүгийн тайлангийн www.ebalance.mof.gov.mn мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана. 2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг дараах шалгуур үзүүлэлтийн аль нэгээр, эсхүл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл; - Арилжааны банкны судлагдсан зээл авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /судалж үзээд зээл олгох боломжтой тухай тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй./; - Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд; 3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа; <p>Уг тодорхойлолтод төлөгдж дуусаагүй зээлийн мэдээлэл “хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. /Зээлийн мэдээллийн сангиин тодорхойлолтыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг хянан үзэхэд харгалзан үзэхгүй./</p>
ТШЗ 20.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм”</p> <ul style="list-style-type: none"> - Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулсан ирүүлнэ. - Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, шинэ, заасан үзүүлэлттэй дүйцэхүйц байхыг баталгаажуулж, албан бичгээр ирүүлнэ; - Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, бараа нийлүүлэх үе шатны хуваарьт багтаан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангах барааг хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ.

	<ul style="list-style-type: none"> - Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар бэлтгэн баталгаажуулж ирүүлнэ. - Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онд ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэн ирүүлнэ. - Ашиглалтад хүлээлгэн өгсний дараа 12 сарын хугацаанд системийг зүгшрүүлэх, жигдрюүлэхээр захиалагчид шаардлагатай зөвлөх үйлчилгээг үзүүлэх үүргийг хүлээх тухай баталгаажуулсан албан бичиг ирүүлнэ. - Авто жингүүд болон гаалийн хяналтын бүсийн шалган нэвтрүүлэх цэгт тоноглох төхөөрөмжүүдийг автомат удирдлагын контроллерт холбож ажиллуулах бөгөөд серверт өгөгдлийг илгээхээр программчилсан бүтцийн зураглалыг ирүүлнэ. - Ажлын даалгаварт өгөгдсөн бүх тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулах, ашиглалтад оруулахтай холбоотой бүх ажлуудыг багтаасан ажлын нарийвчилсан төлөвлөгөөг дэлгэрэнгүй боловсруулж ирүүлнэ. - Тоноглогдсон хэсгүүд хоорондоо хэрхэн холбогдох, ажиллах талаар тодорхой тусгасан бүтцийн зураглалыг /System structure/ боловсруулж ирүүлнэ. <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.</p> <p>Жич: ТӨХ-д шаардсан материалыудын аль нэгийг нь ирүүлээгүй эсхүл шаардлага хангагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”</p>
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтолцол байна”
ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Тийм” Incoterms 2020, DDP Өмнөговь аймгийн Цогтцэций сумас 17 км-т байрлах “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Салбар уурхай.
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн: “Шаардана”</p> <p>10,317,265 төгрөг /арван сая гурван зуун арван долоон мянга хоёр зуун жаран тав/</p> <p>Хүчинтэй байх хугацаа: Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байна.</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5.	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ.</p> <p>Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 6-ийн дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд татгалзах үндэслэл болно.</p>

ТШЗ 26.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТШЗ 26.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Цаг: 10 цаг 30 минут Тендер нээх газрын хаяг: “Эрдэнэс Таван толгой” ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын-8, Финанс төв, 5-р давхар, 504 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 29.2.	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
ТШЗ 31.1.	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: Байхгүй
ТШЗ 32.1	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “Ашиглахгүй”
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 37.1	Гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулахаас өмнө тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй тэнцүү гүйцэтгэлийн баталгааг ирүүлнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ухаалаг пүүний тоног төхөөрөмж болон RFID

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Зорилго

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Борлуулалт, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах, нүүрс тээвэрлэлтийн хяналтыг автоматжуулах, мэдээллийн урсгал, бүртгэлийг сайжруулах зорилгоор RFID уншигчид суурилсан дараах ажлууд хийгдэнэ.

- Автоjingүүдийг автоматжуулах, ухаалаг автоjingийн системийг нэвтрүүлэх.
- Гаалийн хяналтын бүсийн оролт, гаралтын нэвтрэх цэгүүдийг автоматжуулах /Автомат хаалт бүхий нэвтрэх цэг/.
- Нүүрс тээврийн маршрутын тодорхой цэгүүдийг RFID уншигчаар тоноглох.

1.2 Ерөнхий шаардлага

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дээрх зорилгыг бүрэн биелүүлэх үүднээс тендерт оролцогч компани дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна.

- Нийлүүлэгч нь гэрээ байгуулсны дараа, 2 тал ажил эхлэх акт үйлдсэнээс хойш 6 сарын дотор тоног төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулж үйл ажиллагаанд нэвтрүүлэн, ашиглалтад оруулсан байна.
- Ашиглалтад хүлээлгэн өгсний дараа 12 сарын хугацаанд системийг зүгшрүүлэх, жигдрүүлэхээр захиалагчид шаардлагатай зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.
- Автоjingүүд болон гаалийн хяналтын бүсийн шалган нэвтрүүлэх цэгт тоноглох төхөөрөмжүүдийг автомат удирдлагын контроллерт холбож ажиллуулах бөгөөд серверт өгөгдлийг илгээхээр программчилсан бүтцийн зураглалыг ирүүлнэ.
- Ажлын даалгаварт өгөгдсөн бүх тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулах, ашиглалтад оруулахтай холбоотой бүх ажлуудыг багтаасан ажлын нарийвчилсан төлөвлөгөөг дэлгэрэнгүй боловсруулж ирүүлнэ.
- Тоноглогдсон хэсгүүд хоорондоо хэрхэн холбогдох, ажиллах талаар тодорхой тусгасан бүтцийн зураглалыг /System structure/ боловсруулж ирүүлнэ.
- Тоноглолд хэрэглэгдэх RFID уншигч нь тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг унших бөгөөд 0м-20м-ийн зайд UHF Label 860Mhz-960Mhz давтамжийг асуудалгүй унших, LAN сүлжээнд холбогддог гадаа зориулалтын уншигч төхөөрөмж байна.
- Гаалийн хяналтын бүсэд тавигдах ерөнхий хяналтын камер нь 4MP-ээс баагүй нягтаршилтай, genetic системд холбогдож ажиллах гуравдагч орны бүтээгдэхүүн байна.
- Дараах тоног төхөөрөмжүүдэд санал болгож байгаа брэндийн модель загвар, танилцуулгыг заавал тодорхой бичиж, техникийн үзүүлэлтийг харьцуулсан хүснэгтээр боловсруулж ирүүлнэ.
 - Чингэлгийн дугаар таних камер
 - Ерөнхий хяналтын камер
 - RFID уншигч
 - Автомат удирдлагын контроллер
 - Камерын бичлэг боловсруулах, болон хадгалах видео сервер
 - Сүлжээний свич

Нийт худалдан авах үндсэн тоноглол ,төхөөрөмжүүдийн шаардлага, тоо				Харьцуулсан загвар, үзүүлэлт ирүүлэх
№	Төхөөрөмж	Үзүүлэлт	Нийт тоо	
1	Машин мэдрэгч суурилуулах (Хэт улаан туяаны)	<ul style="list-style-type: none"> - 3 м өргөнтэй авто жингийн 2 талаас уншина. - Бетон сууринд суурилуулна. 	42	үгүй
2	Чингэлгийн дугаартаних камер	<ul style="list-style-type: none"> - -30°C, +40°C хэмээс багагүй хэмд хэвийн ажиллах - 4MP-ээс багагүй нягтаршилтай - POE дэмждэг - H265+ эсхүл түүнтэй дүйцэх видео encoding протокол ашиглах. - Чингэлгийн дугаарыг таньж серверт илгээдэг байх. - 4 м-ээс багагүй өндөртэй шонд байрлуулна. - Бетон сууринд суурилуулна. 	56	тийм
3	Мэдээллийн дэлгэц (LED)	<ul style="list-style-type: none"> - LED матрицын дэлгэц - 32 inch-ээс багагүй - 4 м-ээс багагүй шонд байрлуулна. - Бетон сууринд суурилуулна. 	21	үгүй
4	Ерөнхий хяналтын камер	<ul style="list-style-type: none"> - -30°C, +40°C-аас багагүй хэмд хэвийн ажиллах - Суурин чиглэлийн - Genetic системд холбогдох ажиллах - Гуравдагч орны камер байх. - Нягтаршил: 4MP-ээс багагүй - POE дэмждэг - 6 м-ээс багагүй өндөртэй шонд байрлах - Бетон сууринд суурилуулах 	21	тийм
5	RFID уншигч	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг уншина. - Давтамж: Long Range UHF Label 860Mhz-960Mhz хооронд уншина. - Унших зайд: 20м-ээс багагүй зайнаас унших чадвартай байх - LAN сүлжээнд холбогддог байх - RFID таг-аас өгөгдлийг уншин серверт илгээдэг байх. - Шонгийн өндөр: 6м-ээс багагүй - Бетон сууринд суурилуулна. 	36	тийм
6		<ul style="list-style-type: none"> - Пүүний өрөөнд байрлана. 	25	тийм

	Автомат удирдлагын контроллер	<ul style="list-style-type: none"> - Доорх 12 unit-ийн rack-д суурилуулна. - 10th I7, 32G-aac багагүй memory - той удирдлагын процессор бүхий үзүүлэлттэй - ЭТТ ХК-ийн нэгдсэн удирдлагын систем болон бусад шаардлагатай системүүдэд холбогдох API сервис гаргана. 		
7	Чанга яригч домофон систем	<ul style="list-style-type: none"> - Зориулалтын хайрцагт суурилагдана. - LAN сүлжээнд холбогддог байна. - Кабины жолоочтой харалдаа өндөрт байрлах - Бетон сууринд суурилуулах 	25	үгүй
8	Автомат хаалт	<ul style="list-style-type: none"> - Бат бөх төмөр гадаргуутай, болзошгүй үед гар удирдлагаар онгойдог - Мөргөлтөөс хамгаалагдсан хөндлөн онгойдог нугастай - Бетон сууринд суурилуулах. 	46	үгүй
9	Шөнийн гэрэлтүүлэг	<ul style="list-style-type: none"> - Шөнийн цагт чингэлгийн дугаарыг 10м-ээс багагүй зайнлас гэрэлтүүлэх бөгөөд чингэлгийн дугаарыг тод харуулах LED гэрэл - Шонгийн өндөр: 6м - Бетон сууринд суурилуулах 	28	үгүй
10	Гэрлэн дохио	<ul style="list-style-type: none"> - Гэрлэн дохио 3м өндөртэй - Улаан, шар, ногоон 3 өнгөөр асдаг - Бетон сууринд суурилуулах. 	25	үгүй
11	Камерын бичлэг боловсруулах, болон хадгалах видео сервер	<ul style="list-style-type: none"> - PowerEdge R660 Server /дүйцэхүйц/ - Dell ME5012 /дүйцэхүйц/ - Dell EMC ME412 /дүйцэхүйц/ - Cisco MDS 9124V 64-Gbps 24-Port Fiber Channel managed - Switch /дүйцэхүйц/ 	багц	тийм
12	Сүлжээний свич	<ul style="list-style-type: none"> - 1Gbps-ийн хурдтай - 24 портоос багагүй - POE дэмждэг 	21	тийм
13	Сүлжээний свич	<ul style="list-style-type: none"> - 1Gbps-ийн хурдтай - 8 портоос багагүй - POE дэмждэг 	4	тийм
14	Тог баригч /UPS/	<ul style="list-style-type: none"> - 2400 watt-aac багагүй 	36	үгүй
15	RACK	<ul style="list-style-type: none"> - 12-aac багагүй unit 	25	үгүй

		- Пүүлэгчийн байранд байрлуулна.		
16	Бетон суурь /урт/	- Шон суурилуулна.	141	үгүй
		- Урт, өргөн нь 50*50*160		
		- Оролтын авто жинд 16 ширхэг		
		- Гаралтын авто жинд 4 ширхэг		
		- Хяналтын авто жинд 4 ширхэг		
		- Бетон, цемент		
17	Бетон суурь /богино/	- Тоног, төхөөрөмж суурилуулна.	201	үгүй
		- Урт, өргөн нь 50*50*110		
		- Оролтын авто жинд 7 ширхэг		
		- Гаралтын авто жинд 7 ширхэг		
		- Хяналтын авто жинд 7 ширхэг		
18	Төмөр шон /богино/	- Гадаа зориулалттай	46	үгүй
		- 4м-ээс багагүй өндөртэй		
		- Бетон сууринд суурилуулж өгнө		
19	Төмөр шон /урт/	- Гадаа зориулалттай	141	үгүй
		- 6м- ээс багагүй өндөртэй		
		- Бетон сууринд суурилуулж өгнө		
20	Г хэлбэрийн төмөр шон	- Г хэлбэрийн шонгийн гарны урт 2м-ээс багагүй урттай	36	үгүй
		- 6м-ээс багагүй өндөртэй		
		Бетон сууринд суурилуулна.		
21	Кабелийн сувагчлал	- Хоолой диаметр 3см-ээс багагүй	-	үгүй
		- Сүлжээний кабель, цахилгааны кабелийн сувагчлал тусдаа байна.		
22	Сүлжээний кабель	- Гадаа зориулалтын STP кабель Cat6	-	үгүй
23	Цахилгааны кабель	- Зэс	-	үгүй
		- Гадаа зориулалттай.		
		- Ус чийг, хүйтэнд, тэсвэртэй.		

1.3 Төндөрт шалгарсан компанийн хийж гүйцэтгэх ажлын даалгавар (цар хүрээ, байршил)

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайгаас нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг бүртгэх зорилгоор авто жингийн ухаалагжуулах болон, RFID уншигчаар тоноглох ажлуудыг дараах байршуудад гүйцэтгэнэ.

- Нүүрс ачилтын хэсэг дэх гаалийн хяналтын бүс
- Нүүрс тээврийн 8,2 км зам
- Эрдэнэс НАБТ дахь гаалийн хяналтын бүс
- Чингэлэг тээврийн терминал дахь гаалийн хяналтын бүс

Дараах хүснэгтэд тоо ширхгийг харуулав.

№	Байршил	Ажил хийгдэх цэгүүд	Тоо ширхэг
	1. Оролт, гаралтын авто жингийн систем		15
1	Нүүрс ачилтын хэсэг	оролтын авто жин	5

2		гаралтын авто жин	5
3	Эрдэнэс НАБТ дахь гаалийн хяналтын бүс	оролтын авто жин	1
4		гаралтын авто жин	1
5	Чингэлэг тээврийн терминал дахь гаалийн хяналтын бүс	оролтын авто жин	1
6		гаралтын авто жин	2
2. Хяналтын авто жингийн автоматжуулалт			6
7	Нүүрс ачилтын хэсэг	Баруун хяналтын авто жин	2
8		Зүүн хяналтын авто жин	4
3. Гаалийн хяналтын бүсийн оролт, гаралтын нэвтрэх цэгийн автоматжуулалт			4
9	Нүүрс ачилтын хэсэг	10-р пост /оролт/	1
10		11-р пост /гаралт/	1
11	Эрдэнэс НАБТ	Оролт	1
12		Гаралт	1
4. Нүүрс тээврийн маршрутын RFID уншигч байрлуулах			11
13	Нүүрс ачилтын хэсэг	Б талбайн гаралт дээр	1
14		Баруун хяналтаас гараад зүүнээс гардаг уулзвар хүрдэг зам дээр	2
15		Барууны гаралтын авто жин рүү ордог зам дээр	1
16		Зүүн хяналт руу явах дээр	2
17		Зүүний хяналтаас гаралт руу явах зам дээр	1
18	8,2 км зам дээрх цэгүүд	8.2 км замын эхлэх цэг дээр 2 урсгал дээр тус бурд 1	2
19		Түр ачилтын талбай руу орох, гарах зам дээр тус бурд 1	2
НИЙТ АЖИЛ ХИЙГДЭХ ЦЭГ			36

Хоёр. Системийн үйл ажиллагаа, хийгдэх ажил

2.1 Автоjingүүдийг автоматжуулах, ухаалаг автоjingийн системийг нэвтрүүлэх.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн автоjingүүд 40м-ийн урттай бөгөөд оролт, гаралтын автоjин, хяналтын автоjingийн автомат удирдлага нь дараах дарааллаар ажиллана.

1. RFID уншигч төхөөрөмжөөр машиныг таних.
2. Гэрлэн дохионы өнгөөр зөвшөөрлийг шийдэж, орох хаалт онгойх.
3. Хэт улаан туяаны мэдрэгчийн тусламжтайгаар автоjин дээрх тээврийн хэрэгслийн байршилыг автоjин дээр зөв зогссон эсэхийг шийдэж LED дэлгэцэд харуулах.
4. Зөв зогсооны дараа Чингэлгийн дугаар таних камераас Чингэлгүүдийн дугаар болон зургуудыг, автоjingээс тээврийн хэрэгслийн жин, ерөнхий хяналтын камераас пүүлэх үеийн зураг гэх мэт мэдээллүүдийг сервер рүү илгээнэ. (Хяналтын автоjин дээр чингэлгийн дугаар таних камераар тонооголох шаардлагагүй.)
5. Амжилттай хадгалсны дараа LED дэлгэцэд мэдээлэл харуулж гарах хаалтыг онгойлгоно.
6. Асуудал үүсвэл домофоны тусламжтайгаар оператортай харилцах боломжтой байна.

Автоjing дараах байдлаар тонооголож ажиллагаанд оруулж хүлээлгэн өгнө.

- Автоjинд суурилагдах тонооглол, төхөөрөмжүүдийг автомат удирдлагын контроллерт холбож ажиллуулах бөгөөд серверт өгөгдлийг илгээхээр программчлагдсан байна.

- Тоног төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагаанд 24 сарын баталгаат хугацаа өгнө.
- Суурилуулж буй тоноглол, төхөөрөмжүүдийг зориулалтаас хамааруулан автожингийн ойролцоо гадаа хөрсөн дээр болон шонд байрлуулах бөгөөд урт өргөн нь 50см*50см бетон сууринд бат бөх байрлуулна.
- Хөрсөн дээр суурилуулах тоноглолуудын бетон суурь нь газрын гадаргаас доош 30 см-ээс багагүй гүнд суулгах ба нийт урт 110 см байна.
- Төмөр шонгуудын бетон суурь 80 см-ээс багагүй гүнд суулгах ба 160 см байна.
- Автожингийн тоноглолын төхөөрөмжүүдийн холболтын кабель утаснууд нь газрын гадаргаас доош 30 см-ээс багагүй гүнд зориулалтын сувагчлалын хоолой ашиглаж хийгдэнэ.
- Кабелийн зангилаа цэгүүд дээр бетон худагтай байна.



Зураг 1. Бодит харагдах байдал /жишээ/


- Доорх үндсэн тоноглолуудаас гадна тоноглолд шаардлагатай бусад материалуудыг төсөвт багтаан тооцож ирүүлнэ.
- Автожинг тоногллож буй төхөөрөмжүүд нь говийн бүсийн эрс тэс цаг агаар, салхи, шуурга тоосжилттой нөхцөлд уурхайн ачилт, пүүлэлт, тээвэрлэлтийн ажлыг тасалдалгүй ажиллах нөхцөлийг хангах зорилгоор дараах ерөнхий шаардлагуудыг хангасан байна.
- Гадна зориулалттай ус чийг, шороо тоосны хамгаалалттай IP67 стандартыг хангасан байна.
 - Бетон сууринд суурилуулна.

Нэг авто жинд суурилагдах үндсэн тоноглол ,төхөөрөмжүүд				
№	Төхөөрөмж	Тоо ширхэг	Үзүүлэлт (доод)	Ямар автожинд ашиглах
1	Машин мэдрэгч суурилуулах	2	<ul style="list-style-type: none"> - 3 м өргөнтэй авто жингийн 2 талаас уншина. - Бетон сууринд суурилуулах 	<ul style="list-style-type: none"> - Оролт - Гаралт - Хяналт


	(Хэт улаан туяаны)			
2	Чингэлгийн дугаар таних камер суурилуулах	8	<ul style="list-style-type: none"> - -30°C-аас доош, +40°C-аас дээш хэмд хэвийн ажиллах - 4MP-ээс багагүй нягтаршилтай POE дэмждэг - H265+ эсхүл түүнтэй дүйцэх видео encoding протокол ашиглах. - 4 м-ээс багагүй өндөртэй шонд байрлуулна. - Бетон сууринд суурилуулна. 	<ul style="list-style-type: none"> - Оролт
3	Мэдээллийн дэлгэц (LED)	1	<ul style="list-style-type: none"> - LED матрицын дэлгэц - 32 inch-ээс багагүй - 4 м-ээс багагүй шонд байрлуулна. - Бетон сууринд суурилуулна. 	<ul style="list-style-type: none"> - Оролт - Гаралт - Хяналт
4	Ерөнхий хяналтын камер	1	<ul style="list-style-type: none"> - -30°C-аас доош, +40°C-аас дээш хэмд хэвийн ажиллах. - Суурин чиглэлийн - Genetic системд холбогдож ажиллах - Гуравдагч орны камер байх. - Нягтаршил: 4MP-ээс багагүй - POE дэмждэг - 6 м-ээс багагүй өндөртэй шонд байрлах - Бетон сууринд суурилуулах 	<ul style="list-style-type: none"> - Оролт - Гаралт - Хяналт
5	RFID уншигч	1	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг уншина. - Давтамж: Long Range UHF Label 860Mhz-960Mhz хооронд уншина. - Унших зайд: 0м-20м-ээс зайд унших - LAN сүлжээнд холбогддог байх - Шонгийн өндөр: 6м-ээс багагүй - Бетон сууринд суурилуулна. 	<ul style="list-style-type: none"> - Оролт - Гаралт - Хяналт
6	Автомат удирдлагын контроллер	1	<ul style="list-style-type: none"> - Пүүний өрөөнд байрлана. - Доорх 12 unit-ийн rack-д суурилуулна. - 10th I7, 32G-аас багагүй memory - той удирдлагын процессор бүхий үзүүлэлттэй - ЭТТ ХК-ийн нэгдсэн удирдлагын систем болон бусад шаардлагатай системүүдэд холбогдох API сервис гаргана. 	<ul style="list-style-type: none"> - Оролт - Гаралт - Хяналт
7	Чанга яригч домофон системт	1	<ul style="list-style-type: none"> - Зориулалтын хайрцагт суурилагдана. - LAN сүлжээнд холбогддог байна. - Кабины жолоочтой харалдаа өндөрт байрлах - Бетон сууринд суурилуулах 	<ul style="list-style-type: none"> - Оролт - Гаралт - Хяналт
8	Автомат хаалт	2	<ul style="list-style-type: none"> - Бат бөх төмөр гадаргуутай, болзошгүй үед гар удирдлагаар онгойдог - Мөргөлтөөс хамгаалагдсан хөндлөн онгойдог нугастай - Бетон сууринд суурилуулна. 	<ul style="list-style-type: none"> - Оролт - Гаралт - Хяналт
9	Шөнийн гэрэлтүүлэг	4	<ul style="list-style-type: none"> - Шөнийн цагт чингэлгийн дугаарыг 10м-ээс багагүй зайнаас гэрэлтүүлэх бөгөөд чингэлгийн дугаарыг тод харуулах LED гэрэл - Шонгийн өндөр: 6м - Бетон сууринд суурилуулах 	<ul style="list-style-type: none"> - Оролт

10	Гэрлэн дохио	1	- Гэрлэн дохио 3м өндөртэй - Улаан, шар, ногоон 3 өнгөөр асдаг - Бетон сууринд суурилуулна.	- Оролт - Гаралт - Хяналт
11	Сүлжээний свич	1	- 1Gbps-ийн хурдтай - 24 портоос багагүй - РОЕ дэмждэг	- Оролт - Гаралт - Хяналт
12	Тог баригч /UPS/	1	- 2400 watt-aac багагүй	- Оролт - Гаралт - Хяналт
13	RACK	1	- 12-aac багагүй unit - Пүүлэгчийн байранд байрлуулна.	- Оролт - Гаралт - Хяналт
14	Бетон суурь /урт/	-	- Шон суурилуулна. - Урт, өргөн нь 50*50*160 - Оролтын авто жинд 16 ширхэг - Гаралтын авто жинд 4 ширхэг - Хяналтын авто жинд 4 ширхэг - Бетон, цемент	- Оролт - Гаралт - Хяналт
15	Бетон суурь /богино/		- Тоног, төхөөрөмж суурилуулна. - Урт, өргөн нь 50*50*110 - Оролтын авто жинд 7 ширхэг - Гаралтын авто жинд 7 ширхэг - Хяналтын авто жинд 7 ширхэг	- Оролт - Гаралт - Хяналт
16	Төмөр шон /богино/	-	- Гадаа зориулалттай - 4м-ээс багагүй өндөртэй - Бетон сууринд суурилуулж өгнө	- Оролт - Гаралт - Хяналт
17	Төмөр шон /урт/	-	- Гадаа зориулалттай - 6м- ээс багагүй өндөртэй - Бетон сууринд суурилуулж өгнө	- Оролт - Гаралт - Хяналт
18	Г хэлбэрийн төмөр шон	-	- Гадаа зориулалттай - 6м- ээс багагүй өндөртэй - Бетон сууринд суурилуулж өгнө	- Оролт - Гаралт - Хяналт
19	Кабелийн сувагчлал	-	- Хоолой диаметр 3см-ээс багагүй - Сүлжээний кабель, цахилгааны кабелийн сувагчлал тусдаа байна.	- Оролт - Гаралт - Хяналт
20	Сүлжээний кабель		- Гадаа зориулалтын STP кабель Cat6	- Оролт - Гаралт - Хяналт
21	Цахилгааны кабель	-	- Зэс - Гадаа зориулалттай. - Ус чийг, хүйтэнд, тэсвэртэй.	- Оролт - Гаралт - Хяналт


Автожингийн тоноглол нь оролт, гаралтын авто жин, хяналтын авто жингүүдэд зориулалтаасаа шалтгаалан ялгаатай тоноглогдох бөгөөд зураг-4 , зураг-5 зураг-6-д шаарддагдах тоноглолууд болон ялгаатай байдлыг харуулсан.



Зураг 2. Оролтын авто жингиийн иж бүрдэл



Зураг 3. Гаралтын авто жингиийн иж бүрдэл




Зураг 4. Хяналтын авто жингийн тоноглол

2.2 Гаалийн хяналтын бүсийн оролт, гаралтын нэвтрэх цэгүүдийг автоматжуулах /Автомат хаалт бүхий нэвтрэх цэг/

Гаалийн хяналтын бүсийн оролт, гаралтын нэвтрэх цэгүүд нь дараах дарааллаар ажиллана.

1. RFID уншигч төхөөрөмжөөр машиныг таних.
2. Гаалийн хяналтын бүс рүү нэвтрэх болон гарах хөдөлгөөний мэдээллийг серверт илгээнэ.
3. Амжилттай илгээсний дараа гэрлэн дохиогоор удирдаж хаалтыг нээнэ.
4. Асуудал үүсвэл домофоны тусламжтайгаар оператортой харилцах боломжтой байх.



Зураг 5. Гаалийн хяналтын бүсийн оролт, гаралтын нэвтрэх цэгийн тоноглол

Гаалийн хяналтын бүсийн нэвтрэх цэгт ажиллах гарцыг дараах байдлаар тоноглож ажиллагаанд оруулж хүлээлгэн өгнө.

- Гаалийн хяналтын бүсийн шалган нэвтрүүлэх цэгт тоноглол, төхөөрөмжүүдийг автомат удирдлагын контроллерт холбож ажиллуулах бөгөөд серверт өгөгдлийг илгээхээр программчлагдсан байна.
- Тоног төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагаанд 24 сарын баталгаат хугацаа өгнө.
- Суурилуулж буй тоноглол, төхөөрөмжүүдийг зориулалтаас хамааруулан авто жингийн ойролцоо гадаа хөрсөн дээр болон шонд байрлуулах бөгөөд урт өргөн нь 50см*50см бетон сууринд бат бөх байрлуулна.
- Хөрсөн дээр суурилуулах тоноглолуудын бетон суурь нь газрын гадаргаас доош 30 см-ээс багагүй гүнд суулгах ба нийт урт 110 см байна.
- Төмөр шонгуудын бетон суурь 80 см-ээс багагүй гүнд суулгах ба 160 см байна.
- Авто жингийн тоноглолын төхөөрөмжүүдийн холболтын кабель утаснууд нь газрын гадаргаас доош 30 см-ээс багагүй гүнд зориулалтын сувагчлалын хоолой ашиглаж хийгдэнэ.
- Кабелийн зангилаа цэгүүд дээр бетон худагтай байна.
- Доорх үндсэн тоноглолуудаас гадна тоноглолд шаардлагатай бусад материалуудыг төсөвт багтаан тооцож ирүүлнэ.

Тоноглож буй төхөөрөмжүүд нь.govийн бүсийн эрс тэс цаг агаар, салхи, шуурга тоосжилттой нөхцөлд уурхайн ачилт, пүүлэлт, тээвэрлэлтийн ажлыг тасалдалгүй ажиллах нөхцөлийг хангах зорилгоор дараах ерөнхий шаардлагуудыг хангасан байна.

- Гадна зориулалттай ус чийг, широо тоосны хамгаалалттай IP67 стандартыг хангасан байна.
- Бетон сууринд суурилуулна.

№	Төхөөрөмж	Тоо ширхэг	Үзүүлэлт (доод)
1	RFID уншигч	1	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг уншина. - Давтамж: Long Range UHF Label 860Mhz-960Mhz хооронд уншина. - Унших зайд: 0м-20м-ээс зайд унших /түүнтэй дүйцэх/ - LAN сүлжээнд холбогддог байх - Шонгийн өндөр: 6м-ээс багагүй - Бетон сууринд суурилуулна.
2	Автомат удирдлагын контроллер	1	<ul style="list-style-type: none"> - Пүүний өрөөнд байрлана. - Доорх 12 unit-ийн rack-д суурилуулна. - 10th I7 , 32G memory - той удирдлагын процессор бүхий үзүүлэлттэй багагүй - ЭТТ ХК-ийн нэгдсэн удирдлагын систем болон бусад шаардлагатай системүүдэд холбогдох API сервис гаргана.
3	Чанга яригч домофон системт	1	<ul style="list-style-type: none"> - Зориулалтын хайрцагт суурилагдана. - LAN сүлжээнд холбогддог байна. - Кабины жолоочтой хааралдаа өндөрт байрлах - Бетон сууринд суурилуулах
4	Автомат хаалт	1	<ul style="list-style-type: none"> - Бат бөх төмөр гадаргуутай, болзошгүй үед гар удирдлагаар онгойдог - Мөргөлтөөс хамгаалагдсан хөндлөн онгойдог нугастай - Бетон сууринд суурилуулна.


5	Гэрлэн дохио	1	<ul style="list-style-type: none"> - Гэрлэн дохио 3м өндөртэй - Улаан, шар, ногоон 3 өнгөөр асдаг - Бетон сууринд суурилуулна.
6	Бетон суурь /урт/	-	<ul style="list-style-type: none"> - Шон суурилуулна. - Урт, өргөн нь 50*50*160 багагүй - Оролтын авто жинд 16 ширхэг - Гаралтын авто жинд 4 ширхэг - Хяналтын авто жинд 4 ширхэг - Бетон, цемент
7	Бетон суурь /богино/		<ul style="list-style-type: none"> - Тоног, төхөөрөмж суурилуулна. - Урт, өргөн нь 50*50*110 багагүй - Оролтын авто жинд 7 ширхэг - Гаралтын авто жинд 7 ширхэг - Хяналтын авто жинд 7 ширхэг
8	Төмөр шон /богино/	-	<ul style="list-style-type: none"> - Гадаа зориулалттай - 4м-ээс багагүй өндөртэй - Бетон сууринд суурилуулж өгнө
9	Төмөр шон /урт/	-	<ul style="list-style-type: none"> - Гадаа зориулалттай - 6м- ээс багагүй өндөртэй - Бетон сууринд суурилуулж өгнө
10	Кабелийн сувагчлал	-	<ul style="list-style-type: none"> - Хоолой диаметр 3см-ээс багагүй - Сүлжээний кабель, цахилгааны кабелийн сувагчлал тусдаа байна.
11	Сүлжээний кабель	-	<ul style="list-style-type: none"> - Гадаа зориулалтын STP кабель Cat6
12	Цахилгааны кабель	-	<ul style="list-style-type: none"> - Зэс - Гадаа зориулалттай. - Ус чийг, хүйтэнд, тэсвэртэй.
13	Сүлжээний свич	-	<ul style="list-style-type: none"> - 1Gbps-ийн хурдтай - 8 портоос багагүй - PoE дэмждэг

2.3 Нүүрс тээврийн маршрутын RFID уншигч байрлуулах


Нүүрс тээврийн замын RFID уншигчаар тоноглогдсон цэгүүдээр нэвтэрсэн тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг сервер рүү илгээнэ.

Нүүрс ачилтын хэсэг болон 8,2 км зам дээр RFID уншигч байрлуулан автозамын хяналтаар дайран өнгөрөх тээврийн хэрэгслийг хянахад зориулагдсан.

- Тоноглолын төхөөрөмжүүдийг автомат удирдлагын контроллерт холбож ажиллуулах бөгөөд серверт өгөгдлийн илгээхээр программчлагдсан байна.
- Төмөр шонгуудын бетон суурь 80 см-ээс багагүй гүнд суулгах ба 160 см байна.
- Тоноглол, төхөөрөмжүүдийн холболтын кабель утаснууд нь газрын гадаргаас доош 30см ийн гүнд төмөр хоолой ашиглаж хийгдэнэ.
- Кабелийн зангилаа цэгүүд дээр бетон худагтай байна.
- Доорх үндсэн тоноглолуудаас гадна тоноглолд шаардлагатай бусад материалуудыг төсөвт багтаан тооцож ирүүлнэ.



Зураг 6. НАХ хэсэгт RFID уншигч байрлуулах цэгүүд




Зураг 7. 8,2 км зам дээр RFID уншигч байрлуулах цэгүүд

№	Төхөөрөмж	Тоо ширхэг	Үзүүлэлт (доод)
1	RFID уншигч /тээврийн хэрэгсэл/	1	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг уншина. - Давтамж: Long Range UHF Label 860Mhz-960Mhz хооронд уншина. - Унших зайд: 0m-20m-ээс зайд унших /түүнтэй дүйцэх/ - LAN сүлжээнд холбогддог байх - Шонгийн өндөр: 6m-ээс багагүй - Бетон сууринд суурилуулна.
2	Бетон суурь /урт/	1	<ul style="list-style-type: none"> - Шон суурилуулна. - Урт, өргөн нь 50*50*160 багагүй
3	Г хэлбэрийн төмөр шон	1	<ul style="list-style-type: none"> - Г хэлбэрийн шонгийн гарны урт 2m-ээс багагүй урттай

			<ul style="list-style-type: none"> - 6м-ээс багагүй өндөртэй - Бетон сууринд суурилуулна.
4	Кабелийн сувагчлал	-	<ul style="list-style-type: none"> - Хоолой диаметр 3см-ээс багагүй - Сүлжээний кабель, цахилгааны кабелийн сувагчлал тусдаа байна.
5	Бусад (кабель, холбох материал, хар хоолой... гм)	-	<ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний эх үүсвэргүй хэсэгт дунджаар 30 см-ээс багагүй зайнлас тог татах. /Баруун хяналтаас гарад зүүнээс гардаг уулзвар хүрдэг зам дээр/
6	Цахилгааны кабель	-	<ul style="list-style-type: none"> - Зэс - Гадаа зориулалттай. - Ус чийг, хүйтэнд, тэсвэртэй.

Гурав. Камерын бичлэг боловсруулах, болон хадгалах сервер



Үзүүлэлт		Тоо
PowerEdge R660	PowerEdge R660 Server /дүйцэхүйц/	1
Processor	Intel® Xeon® Silver 4410Y	1
Additional Processor	Intel® Xeon® Silver 4410Y	1
Memory Capacity	64GB RDIMM, 5600MT/s	1
RAID Configuration	C3, RAID 1 for 2 HDDs or SSDs (Matching Type/Speed/Capacity)	1
RAID/Internal Storage Controllers	PERC H755 with rear load Brackets	1
Hard Drives	960GB SSD vSAS Mixed Use 12Gbps	2
Power Supply	Dual, Hot-plug, Power Supply Fully Redundant (1+1), Mixed Mode	1
OCP 3.0 Network Adapters	Broadcom 57416 Dual Port 10GbE BASE-T Adapter, OCP NIC 3.0	1
Additional Network Cards	Broadcom 5720 Dual Port 1GbE LOM	1
NVMe and PCIe Storage Adapters	HBA355e Adapter	1
Bezel	Standard Bezel	1
Embedded Systems Management	iDRAC9, Enterprise 16G	1

Rack Rails	ReadyRails Sliding Rails With Cable Management Arm	1
Warranty	3 years	1
Storage	Dell ME5012 /дүйцэхүйц/	1
Controller Cards	12Gb SAS 8 Port Dual Controller	1
Hard Drives	16TB 7.2K RPM SAS 12Gbps 512e 3.5in Hot-plug Hard Drive	12
Rack Rails	Rack Rails 2U	1
Bezel	ME Series 2U Bezel	1
Power Supply	Power Supply, 580W, Redundant, WW	1
Warranty	3 years	1
Storage expansion	Dell EMC ME412 /дүйцэхүйц/	1
Bezel	ME Series 2U Bezel	1
Hard Drives	16TB 7.2K RPM SAS 12Gbps 512e 3.5in Hot-plug Hard Drive	12
Rack Rails	Rack Rails 2U	1
Power Supply	Power Supply, 580W, Redundant, WW	1
SAS Cables	2x12Gb HD Mini-SAS to HD Mini-SAS 2M Cable	1
Warranty	3 years	1
SAN switch	Cisco MDS 9124V 64-Gbps 24-Port Fiber Channel managed Switch /дүйцэхүйц/	1
Total System Ports	SFP*24	24
Management port	console RS232	1
Status LEDs	Power, Fault, LAN Mode, FC port	1
Security protocols	VSAN fabric isolation Secure FTP (SFTP) Secure Shell Protocol Version 2 (SSHv2) SNMPv3 NVMe/FC	1
Functions	VSAN, IVR, NPV Port Channel with multipath load balancing Flow- and zone-based QoS	1
power supplies	500W PSU AC input: 100 to 240 VAC (10% range) swapable	1
Jumper cable		24
SFP module		24

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	Ухаалаг пүүний тоног төхөөрөмж, нэвтрэх систем	Техникийн тодорхойлолтод тусгагдсаны дагуу	Багц	Өмнөговь аймгийн Цогтцэций сумас 17 км-т байрлах “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Салбар уурхай.	Гэрээ байгуулсны дараа, 2 тал ажил эхлэх акт үйлдсэнээс хойш 6 сар хүртэл	

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

IV.2. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 29.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн санаалаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Бараа хүргэх, ажил, үйлчилгээ дуусгах хугацаа: “**Ашиглахгүй**”
1. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: “**Ашиглахгүй**”
2. Байгаль орчинд нөлөөлөх байдал: “**Ашиглахгүй**”
3. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: “**Ашиглахгүй**”

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1. Тендер илгээх маягт

Маягт 2. Барааны үнийн задаргаа

Маягт 3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Тендер илгээх маягт
Маягт 1

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээнээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догондолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.
[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

Маягт 2 Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ²	Тоо хэмжээ	Хэмжи х нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ³
1										Тийм/Үгүй
2										
...										
							Тендерийн нийт үнэ			

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг, байгууллагын
тамга, тэмдэг]:

² ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

³ Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3 Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 4 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1. Захиалагчийн нэр
2. Гэрээний нэр
3. Гэрээний дугаар
4. Гэрээ байгуулсан огноо
5. Гэрээ дуусгавар болсон огноо
6. Гэрээний дүн
7. Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил

	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч
--	---

Маягт 6 **Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэрэгээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албан д нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
 - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
 - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
 - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
 - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
 - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдолыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
 - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөг” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй

	шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
Бараа нийлүүлэх газар	2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
Барааг хүлээлгэн өгөх	2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Барааны гарал үүслийн улс	2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
Баглаа боодол	<p>2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <ul style="list-style-type: none"> 2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон. <p>2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.</p> <p>2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.</p> <p>2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.</p> <p>2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.</p> <p>2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.</p> <p>2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.</p> <p>2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.</p>

	2.16	Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
Худалдааны нөхцөл	2.17	Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.
	2.18	ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарыг дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
Гүйцэтгэлийн баталгаа	2.19	Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн З хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
	2.20	Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна:
	2.20.1	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
	2.20.2	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
	2.20.3	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
	2.21	Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
	2.22	ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
	2.23	Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.
		ГУРАВ. ЗАХИАЛАГЧ
Барааг хүлээн авах	3.1	Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
Шалгалт, туршилт	3.2	Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
	3.3	Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

- 3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.
- 3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.
- Гэрээний үнэ
- 3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
- Төлбөр төлөх
- 3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
- 3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.
- ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА**
- Захиалагчийн хүлээх эрсдэл
- 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;
- 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.
- Даатгал
- 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид

- ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
- Доголдол
- 4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
 - 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
 - 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
 - 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
 - 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
 - 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
 - 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас сүутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- Чанарын баталгаа
- 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.
 - 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.
 - 4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.
 - 4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
 - 4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
 - 4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг сүутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.
 - 4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
 - 4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн
- Алданги

		дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
Оюуны өмчийн эрх зөрчих	4.18.	Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал	4.19.	Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	4.20.	Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
	4.21.	Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
	4.22.	Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
	4.23.	Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.
	4.24.	Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
	4.25.	Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах,
гэрээг цуцлах үндэслэл

- 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
 - 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;
 - 5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;
 - 5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.
 - 5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.
- 5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.
- 5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.
- 5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.
- 5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

Төлөөлөгч

- 6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.
- 6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.
- 6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

- | | |
|----------------------------------|---|
| Туслан гүйцэтгэгч | <p>6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p> |
| Нууцлал | <p>6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p> |
| Мэдэгдэл | <p>6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9-д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <ul style="list-style-type: none"> 6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн; 6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн. <p>6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p> |
| Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах | <p>6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <ul style="list-style-type: none"> 6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан; 6.15.2. үнийн тохируулга хийсэн. |

Маргаан шийдвэрлэх

- 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
- 6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас 17 км-т байрлах “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Салбар уурхай
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх хугацаа: Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа: Гэрээ байгуулсны дараа, 2 тал барааг нийлүүлэх, ажил эхлүүлэх акт үйлдсэнээс хойш 6 хүртэлх сарын хугацаанд угсарч суурилуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэн, ашиглалтад оруулсан байна.
ГЕН 2.10.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: Барааг захиалагчийн шаардсан бараа хүргэх эцсийн цэгт хүргэж, угсарч суурилуулан ажиллагаанд бүрэн оуулна. Бараанд холбогдох баримт бичиг: Нэхэмжлэх, зарлагын баримт, бараа хүлээлцсэн акт болон бусад холбогдох баримт бичиг.
ГЕН 2.14.	Баглаа, боодол: Тээвэрлэх, хадгалах үедээ ус бороо, галын аюулаас бүрэн хамгаалагдсан зориулалтын саванд хийж барааны чанарыг алдагдуулахгүй байна.
ГЕН 2.17.	Худалдааны нөхцөл: Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Тийм” Incoterms 2020, DDP нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт угсарч суурилуулна.
ГЕН 3.8.	Үнийн тохирнуулга хийх аргачлал: Үнийн тохирнуулга хийхгүй тогтмол байна.
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: Захиалагч нь нийлүүлэгч талд урьдчилгаа төлбөр олгохгүй бөгөөд төлбөрийг гүйцэтгэлээр олгоно. /Гэрээний хэрэгжилтийн явцад 2 тал барааг нийлүүлж, угсарч, үйл ажиллагаанд бүрэн оруулахтай холбоотой явцын тайлан гаргасныг үндэслэн гүйцэтгэлээр олгоно./
ГЕН 4.2.	Даатгал: Гүйцэтгэгч тал барааг нийлүүлж, угсарч, ажиллагаанд оруулахтай холбоотой шаардлагатай /ажил олгогчийн, ажилтны эрүүл мэндийн, техник, тоног төхөөрөмжийн гэх мэт/ даатгалд хамрагдсан байх шаардлагатай ба даатгалтай холбоотой аливаа асуудал, маргаанд захиалагч хариуцлага хүлээхгүй.
ГЕН 4.10.	Баталгаат хугацаа: Баталгаат хугацаа 24 сар
ГЕН 4.11	Чанарын баталгаа: : Гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцүү байна.
ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги оногдуулах хувь: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байна. Алдангийн нийт хэмжээ: Гэрээний үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй.
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги: Алданги оногдуулах хувь: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байна. Алдангийн нийт хэмжээ: Гэрээний үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт;
 - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр**

Тендер шалгаруулалтын төрөл: **Бараа**

Тендер шалгаруулалтын нэр: **Ухаалаг пүүний тоног төхөөрөмж,
нэвтрэх систем нийлүүлэгчийг сонгох**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЭТТХК/20240102487**

Нийт төсөвт өртөг: **2,063,453,000 төгрөг**

Тендер шалгаруулалтын арга: **Нээлттэй**

1. “**Эрдэнэс Тавантолгой**” ХК нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **Багцгүй**

Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бичих: **Үгүй**

3. Тендерийг **2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**

5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхтэй”**

6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Тийм”**

Тендерийн баталгааны дүн: **10,317,265 /Арван сая, гурван зуун арван долоон мянга,
хоёр зуун жаран тав/ төгрөг**,

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**

10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

“**Эрдэнэс Тавантолгой**” ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын-8,

Финанс төв, 5-р давхар, 504 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс

Утас: 75055555. дотуур утас-512